



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/176

Мандалговь

Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан  
оготной тэмцэх үзүүлэх сургуулилтыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, 32.1.9, 32.1.10 дахь заалт, Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалт, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Бэлчээрийн мэрэгч амьтан үлийн цагаан оготной энгийн механик аргаар тэмцэх үзүүлэх сургуулилтыг Дэрэн сумын Алаг Өндөр багийн нийт 25,0 мянган га бэлчээрийн талбайд 2019 оны 5 сарын 6 өдрөөс эхлэн 1 хоногт багтаан явуулсугай.

Хоёр. Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготной энгийн механик аргаар тэмцэх сургуулилтын арга хэмжээг зохион байгуулахтай холбогдуулан мэргэжлийн анги, албадыг бүрэн бүрэлдэхүүнээр хамруулж, технологийн дагуу үр дүнтэй, чанартай гүйцэтгэж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд мөрдөж ажиллахыг мэргэжлийн анги, албадын дарга нарт үүрэг болгосугай.


Гурав. Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной тэмцэх үзүүлэх сургуулилтад Дэрэн сумын Онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, 20 малчдыг бүрэн хамруулахыг сумын Засаг дарга Н.Мядагмаад хариуцуулсугай.

Дөрөв. Ажлын явцад байнгын хяналт тавьж, илэрсэн дутагдал, зөрчлийг цаг алдалгүй арилгаж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар Ш.Төрбатад үүрэг болгосугай.

Тав. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй гамшгаас хамгаалах команд штабын сургалтын үеэр хийгдэх үлийн цагаан оготной энгийн механик аргаар тэмцэх сургуулилтын ажлыг зохион байгуулсан тайлан, үр дүнгийн талаар аймгийн Онцгой комисст танилцуулахыг Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхжаргалд даалгасугай.

Зургаа. Мэргэжлийн анги, албадын бүрэлдэхүүнийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга М.Адьяабаатар, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхжаргал нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ 488190472